



## “АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭЭ” АЯН ӨРНҮҮЛЭХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, халдвараас сэргийлэх эрүүл ахуйн зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд оршино.

Уриа: “Амны хаалт-Бидний аюулгүйн баталгаа”

Хоёр. Хугацаа:

Аяныг 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.

Гурав. Хамрах хүрээ:

Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх төрийн, олон улсын болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд.

Дөрөв. Зохион байгуулах байгууллага:

Аяныг аймаг, нийслэлийн Засаг дарга, онцгой комисс, холбогдох яам, агентлаг, олон улсын болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд.

Тав. Хэрэгжүүлэх ажил:

- Иргэд хоорондоо зөвхөн 1-4 метр зайнаас харьцах, бие биедээ шаардлага, хяналт тавих, хувь хүний ухамсар, соёлыг дэлгэрүүлэх, амны хаалтыг зүүж хэвших, гэртээ байх дэглэмийг бүх түвшинд чандлан сахих, хяналтыг чангатгах,
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд зөвхөн амны хаалт хэрэглэсэн хүнд үйлчилдэг хатуу дэглэм тогтоох,
- Халдварын эрсдэлийг бууруулах чиглэлээр хэвлэл мэдээллийн бүх байгууллага (телевиз, радио, сонин, төрөл бүрийн цахим хуудас, багц мессеж)-аар заавар, зөвлөмжийг хүртээмжтэй, давталттай, тасралтгүй хүргэх,

- Мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тусгай тоноглогдсон автомашин болон зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхагаар дамжуулж хорооллын дундах зам, нийтийн эзэмшлийн талбайд давтамжтай түгээх, нийгмийн сүлжээгээр “Би амны хаалтаа тогтмол зүүдэг” мэссэж бүхий амны хаалттай профайл зураг тавих, 10-аас доошгүй найзаа челленжид дуудах аян өрнүүлэх,

- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ажиллах байнгын эргүүл, байцаагчдын тоог нэмэгдүүлэх, хяналт, шалгалтыг эрчимжүүлэх.

Зургаа.Хүрэх үр дүн:

Аливаа агаар дуслын замаар дамжих халдвараас сэргийлнэ.

Долоо. Хяналт, хариуцлага:

Аймаг, нийслэлийн Засаг дарга, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллага, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн сайн дурын ажилтан, дүүрэг, хорооны нийгмийн ажилтан, сууц өмчлөгчдийн холбоо, олон нийтийн байцаагч, хөршийн холбоо, иргэдийн оролцоотой хяналтыг тавьж, илэрсэн зөрчилтэй уялдуулан холбогдох байгууллага Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хариуцлага тооцно.

Найм. Аяны хүрээнд хийсэн ажлын тайлан:

Аймаг, нийслэлийн онцгой комисс аяны хүрээнд хийгдсэн ажлыг нэгтгэн 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын онцгой комиссын Шуурхай штабт ирүүлнэ.

---oOo---